

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН ХӨРӨНГИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2020/6/-НА

БУЛГАН ХОТ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг:
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
Ахлах аудитор Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг:
Аудитор З.Ганбаатар

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудитын бүрэлдэхүүн, хугацааны мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ.....	9-14
БҮЛЭГ 2. АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН ЭСЭХ.....	14-17
БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ	
ДҮГНЭЛТ.....	18-19
ЗӨВЛӨМЖ.....	19-20

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
БОАЖЯ	Байгаль, орчин, аялал, жуулчлалын яам
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НА	Нийцлийн аудит

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд зарцуулахаар хуваарилсан хөрөнгө	9

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2019 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	12

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	2019 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сумдаар/	21
Хавсралт 2	Сумдын байгаль хамгаалах сангийн орлогын задаргаа	22
Хавсралт 3	2016-2019 онуудад хийгдсэн ойжуулалтын судалгаа	23
Хавсралт 4	Захиалагчийн албаны зардал, магадалиггүй ажлын зардал, зохиогчийн ажлын зардал, техник хяналтын зардал, зураг төсвийн үнийг гүйцэтгэх ажлын гэрээнд тусгаагүй, тухайн зардлыг суутгаж аваагүй судалгаа	24

**Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх****Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн
талаарх мэдэгдэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

Аудитын зорилт

Байгаль хамгаалах сангийн 2019 оны үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг аймгийн засаг дарга, ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль журмын дагуу төлөвлөсөн эсэх
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хууль хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалтад тавих хяналтыг хууль журамд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

**Аудитын хамарсан
хүрээ**

Тус аудитаар БОАЖГ болон тэдгээрийн харьяа холбогдох байгууллагууд, аймаг, сум, ИТХ, ЗДТГ, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар бусад байгууллага, албан тушаалтны 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулж, тухайн байгууллага, албан тушаалтны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын төлөвлөх бүрдүүлэхтэй холбогдох шийдвэр, хувийн хэрэг, баримт материалыг түүвэрлэн шалгалаа.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан аудитад хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын байгаль орчны нөхөн сэргээлттэй холбогдох баримт материал, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Захиргааны ерөнхий хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль
- Ойн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Усны тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Амьтны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах зарцуулах, тайлагнах журам”
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын “Босго үнэ батлах тухай” 2013 оны 68 дугаар тогтоол, Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаал
- Аймгийн ИТХ-ын 2014 оны “Байгаль хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах журам”

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2020 оны 05дугаар сарын 01-ны өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 04-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 06 дугаар сарын 23-ны өдрөөс тус тус эхлүүлэн гүйцэтгэж, аудитын нэгдсэн тайланг 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан ИТХ, аймгийн ЗД хүргүүлэхээр байсан. Үндэсний аудитын газраас 2020 оны аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан бөгөөд тухайн тайлангийн гүйцэтгэлийн шатанд нэгдсэн удирдамжтай /хуулийн хугацаанд хийж гүйцэтгэх/ аудитуудыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан тэргүүлэх аудиторовн тушаалаар аудитын хугацааг сунгасан болно.

	Аудитыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл	ҮАГ 2020 хийж гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулснаар тухайн аудитыг хойшлуулсан, тухайн аудитыг хийж гүйцэтгэхэд нэг аудиторыг хийж гүйцэтгэхээр оруулсан нь аудитыг цаг хугацаанд, төлөвлөсөн зорилгодоо хүрсэн үр дүн гаргахад хүндрэлтэй байлаа.
Ерөнхий мэдээлэл	Булган аймгийн хэмжээнд 13 суманд байгаль хамгаалах сангийн данстай байна. Аймгийн Байгаль хамгаалах сангийн дансыг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон 2015 оны 01 дүгээр сараас Сангийн сайдын 2015 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 07 тоот тушаалаар байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын данс болгон өөрчилсөн байна. “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлд заасныг үндэслэн Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор анх “Байгаль Хамгаалах Сан” байгуулагдсан. Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор “Байгаль Хамгаалах Сан”-гийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар “Байгаль Хамгаалах Сан”-гийн үйл ажиллагааг өргөтгөн “Байгаль Орчин, Уур Амьсгалын Сан” болгон өөрчлөн байгуулсан байна. Мөн Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1, 13.4, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”- 2.1, 3.1 -д заасны дагуу сангийн орлогыг бүрдүүлж, зарцуулж, тайлагнахаар эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн байна.

Бүлэг 1**Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль журмын дагуу төлөвлөөгүй байна.****1.1.1 Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос бусад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт бодит бус байна.**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар аймаг, сумын ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулахаар заасан байна. Мөн Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1¹, 13.4², Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”- 2.1³, 3⁴ -д заасны дагуу бүрдүүлэхээр заажээ.

Аймаг, сум байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Аймгийн төсөвт:

- Газар ашигласны төлбөр – 245000.0 мян.төг
- Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигласны төлбөрийг – 15500000.0 мян.төг

Сумдын төсөвт:

- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого – 36358.0 мян.төг
- Байгалийн ургамал ашигласны төлбөр – 1200.0 мян.төг
- Ойн нөөц ашигласны төлбөр – 296510.0 мян.төг
- Ахуйн зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр – 49886.0 мян.төг

Аймаг, сумын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг судалж үзэхэд орлогыг төлөвлөхдөө нарийвчилсан судалгаа хийхгүй, үндэслэл муутай, зөвхөн өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн байна.Тухайлбал:

- Газрын төлбөрийн орлогын ногдуулалтыг нэг бүрчлэн тооцож, судалгаа шинжилгээ хийгээгүй,
- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг Сангийн яам 14579.8 сая төгрөгөөр хянасныг 686.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 15500.0 сая төгрөгөөр өмнөх оны гүйцэтгэлд үндэслэсэн, мөн уул уурхайн олборлолт явуулдаг аж

¹ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

² Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

³ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

⁴ Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт

ахуй нэгжүүдийн ус ашигласны орлогын дутууг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч холбогдох тооцоо судалгаа байхгүй,

- Сангийн яаманд ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг хянуулаагүй өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөсөн,
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогыг ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслээгүй /ойн менежментийн төлөвлөгөөний хугацаа дууссан/ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан “Ойгоос мод бэлтгэх тухай журам”-ын 2.3⁵-т заасан заалттай бүрэн нийцээгүй,
- Ахуйн зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг ямар тооцоо судалгаанд үндэслэн тооцсон нь тодорхойгүй бөөн дүнгээр төлөвлөсөн байна.

Иймд цаашид байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, усны дүгнэлт болон бусад үзүүлэлтийг үндэслэн бодитой тооцоо, судалгаанд төлөвлөж байх шаардлагатай байна.

1.1.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6⁶, 23.8⁷-д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны төлбөр, газрын төлбөрийг аймгийн төсөвт, ан амьтан, байгалийн ургамал, ой, хүн амын унд ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөрийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж байна.

Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нийт 15883.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 14758.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 92.9 хувиар биелүүлсэн байна.

Аймаг, сумын байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулбал:

2019 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



⁵ Аймаг, нийслэлийн Засаг дарга аймгийн ойн менежментийн төлөвлөгөөнд заасан жилд бэлтгэх модны боломжит хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр, сумдын саналыг үндэслэн өөрийн аймгийн ойн сангаас дараа жилд бэлтгэх модны талаарх саналаа Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ.

⁶ Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

⁷ Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

Төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг аймаг, сумдаар нь задалж үзэхэд:

- Аймаг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 1153.0,
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг Булган сум 0.53, Сайхан сум 1.75, Сэлэнгэ сум 6.4, Тэшиг сум 4.11,
- Агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг Баян-Агт сум 0.17, Баяннуур сум 0.42, Бугат сум 0.73, Орхон сум 0.02, Сэлэнгэ сум 0.18, Тэшиг сум 4.71, Хутаг-Өндөр сум 10.9,
- Ургамал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг Бугат сум 0.55,
- Ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг Бугат сум 0.41, Булган сум 1.2 сая төгрөгөөр тус тус дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл нийт дүнгээрээ 161.1 хувьтай биелсэн байгаа ч зарим сумд тухайн орлогыг үнэн бодитой төлөвлөөгүйгээс нийт орлогын төлөвлөгөөний биелэлт хэт өндөр дүнтэй давж биелсэн ба энэ нь тухайн орлогыг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна. /Хавсралт-1/

Мөн аудитын явцад сумдын байгаль хамгаалагч нар ойн нөөц ашигласны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийн бэлнээр хураасан орлогыг төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн. Үүнд:

- Хутаг-Өндөр сумын Хонгор багийн байгаль хамгаалагч 2019 оны ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн 200.0, Хантай багийн байгаль хамгаалагч 110.0, Уньт багийн байгаль хамгаалагч 2019 оны ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 352.3, Тээл багийн байгаль хамгаалагч 2018 оны ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 295.7, 2019 оны 856.4,
- Сэлэнгэ сумын байгаль хамгаалагчид 2020 оны ойн нөөц ашигласны төлбөрийн 1144.6,
- Тэшиг сумын байгаль хамгаалагч 2019 оны ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 840.0,
- Хангал сумын байгаль хамгаалагч 2019 оны ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 460.8,
- Могод сумын байгаль хамгаалагч 2018 оны ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 166.3, 2019 оны 607.4 мянган төгрөгийн орлогыг төсөвт тус тус төвлөрүүлээгүй зөрчлийн нийт 5033.5 мянган төгрөгийг аудитын явцад барагдуулж ажилласан.

Дээрх илэрсэн зөрчил нь байгаль хамгаалагчийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны удирдлагаас тавих хяналт сул, сумын удирдлагаас тавьсан шаардлагыг биелүүлдэггүй, байгаль хамгаалагчийн эрхийн бичгийн зарцуулалт, орлого төвлөрүүлэлтэд тавигдах дотоод хяналт байхгүйтэй холбоотой байна. Цаашид байгаль хамгаалагчийн байгалийн нөөц ашигласны эрхийн бичгийн зарцуулалт хяналтыг тогтмол хийх шаардлагатай байна.

1.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг сумдын түвшинд холбогдох хууль, журамд нийцүүлэн төлөвлөхгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1⁸, 13.4⁹, ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 2.1¹⁰ дэх заалтад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоор санхүүжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар заасан байна.

Орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд хуваарилсан хөрөнгийг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасан хэмжээгээр тооцож үзэхэд 5731934.5 мянган төгрөгийг хуваарилахаас 325226.7 мянган төгрөгөөр дутуу буюу 5406707.8 мянган төгрөг зарцуулах хязгаарыг Сангийн яам тогтоосон байна.

Аймгийн ИТХ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд Сангийн яамнаас тогтоосон 5406707.8 мянган төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд зарцуулахаар хуваарилсан хөрөнгө

№	Орлогын төрөл	Жилийн батлагдсан орлогын дүн	Байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулахаар батлагдсан дүн	Орлогын хувь, хэмжээний доод хязгаар	Хуулийн дагуу нөхөн сэргээхэд зарцуулах дүн	Зөрүү /Илүү (дутуу)/
1	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	1,200.00	3,000.00	15%	450.00	2,550.00
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	35,942.00	36,000.00	50%	17,971.00	18,029.00
3	Газрын нөөцийн төлбөрийн орлого	245,000.00	1,419,220.00	15%	36,750.00	1,382,470.00
4	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	296,510.00	978,129.90	85%	252,033.50	726,096.40

⁸ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

⁹ Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

¹⁰ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

5	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	15,500,000.00	2,966,357.90	35%	5,425,000.00	(2,458,642.10)
6	Үйл ажиллагааны зардал		4,000.00			4,000.00
Дүн		16,078,652.00	5,406,707.80		5,732,204.50	(325,496.70)

Дээрх хүснэгтээс дүгнэхэд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулж буй хөрөнгийн дүн хуульчилсан хувь хэмжээнд хүрэхгүй, усны нөөцийг нөхөн сэргээхэд орлогын 19.1 хувийг зарцуулахаар буюу 45.3 хувиар дутуу, бусад байгалийн нөөцийг нөхөн сэргээх зардалд хуулиар заагдсан хувь хэмжээнээс 288.1-3776.1 хувиар давсан дүнгээр буюу дутуу хуваарилсан зардлаас бусад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд зарцуулахаар төлөвлөсөн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1¹¹ дэх заалттай бүрэн нийцэхгүй байна.

Сумдын түвшинд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг сумын байгаль хамгаалах санд төвлөрсөн орлогын хэмжээнд төлөвлөн зарцуулж байна. Тухайлбал: Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагуудын нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө, өвс тэжээлийн үнэ /Бугат, Орхон сум ГХС, БХС-гийн хөрөнгө нэг данстай байдаг/, зөвшөөрөлгүй байгалийн нөөц ашигласны торгууль, хураагдсан модны иргэдэд борлуулсны орлого, иргэд аж ахуй нэгжийн хэрэглээний модны ойн нөхөн сэргээлтийн төлбөр, агнуурын зөвшөөрлийн орлого, түгээмэл тархацтай байгалийн нөөц ашигласны төлбөр зэрэг орлогуудыг байгаль хамгаалах санд төвлөрүүлж сумын Засаг даргын баталсан “*Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам*”-ын дагуу тухайн сангийн хөрөнгийг ИТХ-аар батлуулж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Байгаль хамгаалах сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн төлөвлөж байна. /хавсралт-2/

Сумын Засаг дарга, ИТХ байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд зарцуулах төсвийг батлахгүй, орон нутгийн урсгал зардалд зарцуулж байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1¹², 13.4¹³, Ойн тухай хуулийн 18.1.1¹⁴, 18.2.2¹⁵, Амьтны тухай хуулийн 5.7¹⁶,

¹¹ Энэ хуулийн 13.2-г заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

¹² Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

¹³ Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

¹⁴ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээнд шаардагдах төсвийг батлах, биелэлтэд хяналт тавих;

¹⁵ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

¹⁶ харьяалах нутаг дэвсгэртээ байршдаг амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг байгаль орчны хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх;

Ургамал хамгааллын тухай хуулийн 9.1.1¹⁷, Төсвийн тухай хуулийн 6.6.6¹⁸, ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 2.2¹⁹ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд сумдын Засаг дарга, ИТХ дээр дурдсан хуулийн заалт, ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.2.²⁰ заалтуудыг үндэслэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан холбогдох хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

Мөн сумын Засаг дарга нар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлж БОАЖГ-т ирүүлээгүй байна. Энэ нь ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн орлогын хэсгийн тайлагнах, хяналт тавих журмын 4.1²¹ дэх заалтыг зөрчсөн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Сумдын баримтлан ажиллаж байгаа “Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам” нь Засаг даргын 2010 оны 298 дугаар захирамжийг үндэслэн баталсан байх бөгөөд уг журам нь аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/435 дугаар захирамжаар хүчингүй болсон байна.

Аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/435 дугаар захирамжаар баталсан “Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам” хүчинтэй байгаа боловч уг журмыг баримталж ажилладаггүй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хэмжээг ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн орлогын хэсгийн тайлагнах, хяналт тавих журмаар зохицуулж байна.

Мөн Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын тусгай сангийн “Байгаль хамгаалах сан” -гийн журам Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор хүчингүй болсон байна.

Иймд Засаг даргын 2015 оны 12 дугаар 31-ний өдрийн А/435 дугаар захирамж, сумдын баримтлан ажиллаж байгаа байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмын үндэслэл, агуулга, хууль эрх зүйн орчныг судалж холбогдох шийдвэрийг гаргуулах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

¹⁷ нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, зардлын төслийг хэлэлцэж батлах, биелэлтэд хяналт тавих;

¹⁸ Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

¹⁹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна

²⁰ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна

²¹ Сум, дүүргийн Засаг дарга нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

Бүлэг 2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зарим арга хэмжээнд зарцуулсан зардал үр дүнгүй, зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.1. Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлсэн зарим төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлаагүй байна.

2.1.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний 9.5 хувийг зураг, төсөв, эдийн засгийн тооцоололгүйгээр төлөвлөж батлуулсан байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх төсөл арга хэмжээнд зарцуулах зардалд нийт 73 төсөл хэмжээний 5406707.8 мянган төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХ-аар батлуулсан.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө зураг, төсөв, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, хөтөлбөргүйгээр нийт 7 төсөл арга хэмжээнд 268000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29.4, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.1.3 дахь заалт бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал:

- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд - /Булган сум -40.0, Хишиг-Өндөр сум-10, Орхон сум-5.0, Сэлэнгэ сум-5,0/ нийт 70000.0 мянган төгрөгийг төлөвлөснөөс Булган сумаас бусад сумын урьдчилсан тооцоо судалгаа, төсөвт өртөг байхгүй
- Сав газруудын талуудын оролцооны зөвлөлийн хурал, зөвлөгөөнд- 15000.0,
- Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтэд-38000.0,
- Булган сумын өрхийн эрүүл мэндийн төвийн халаалтын тогоог шинэчлэхэд-10000.0,
- “Цэвэр орчин” аяныг 16 сум, 1 тосгонд зохион байгуулахад - 17000.0,
- Орхон сумын хогийн цэгийн даланг засварлахад-8000.0,
- Ногоон хөгжлийн бодлогын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх-150000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө төлөвлөлтийн шаардлагыг хангахгүй төлөвлөх нь тухайн зардлыг үр дүнгүй, төсөвт өртгийг хэтрүүлэх, зориулалт бусаар зарцуулах эрсдэл үүсэж байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.1.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 4.9 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3-д заасныг мөрдөхгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх нийтлэг арга хэлбэрт тусгагдаагүй ажил, мөн төсөвт байгууллагын хөрөнгө оруулалтын чанартай нийт 8 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 228373.6 мянган төгрөг буюу нийт зардлын 4.9 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Бүх төрлийн зургийг хэвлэх плоттер хэвлэгч худалдан авахад /Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар/ 17200.0
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэхэд /Тусгай зориулалттай автомашин, багаж техник хэрэгсэл/ 40000.0
- Байгаль хамгаалагчдын иж бүрэн ажлын хувцас худалдаж авахад 28950.0
- Айрагны фестивалд 44570.0
- “Эв мод-бага Алтаргана” наадамд 15000.0
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ үйлдвэрлэх, хөгжүүлэх түгээхэд 44653.6
- Хангинахын шугуйн шагайн тойром эвент арга хэмжээнд 3000.0
- Байгаль орчин аялал жуулчлалын газарт албан хэрэгцээний автомашин худалдан авахад 35000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, санхүүжилтийн задаргааг ИТХ хянаж батлахдаа Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дахь заалтыг мөрдөхгүйгээр баталсантай холбоотой байна.

Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсоох зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

2.1.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ холбогдох хууль дүрэм журамд бүрэн нийцээгүй байна.

Тухайн онд Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд өмнөх оны 5, тухайн оны 67 нийт 73 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 69 төсөл арга хэмжээнд 4575337.3 мянган төгрөгийг зарцуулж, Булган аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилэн кабель татах, Сав газруудын хамгаалалтын бүс тогтоох, Булган сумын үерийн далан шинэчлэн засварлах /Булган сум 6-р хэсэг/ төсөл хөтөлбөр арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын зарцуулалтын гүйцэтгэлийг үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

➤ Ойжуулалтын ажил үр дүнгүй байна.

Аймгийн хэмжээнд 2016-2019 онуудад 6 суманд нийт 1200 га талбайд ойжуулалт хийж ойжуулалтын зардалд нийт 823.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр нийт 651.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар ойжуулалт хийсэн талбайг газар дээр нь очиж үзэхэд ойжуулалт хийсэн тарьцын амьдралын хувь ойролцоогоор 10 хувьд хүрэхгүй ойг нөхөн сэргээх ажил ямар ч үр дүнгүй байна. /хавсралт-3/

Ойжуулалт үр дүнгүй байгаа гол шалтгаан нь сумын ЗДТГ, БОАЖГ, ойн анги, байгаль хамгаалагчийн зүгээс ургалтын хувь, нөхөн тарилт хийж арчилгаа хийсэн эсэхийг жил бүр үзэж, хяналт тавьдаггүй, хариуцлагагүй ханддаг, ойжуулсан талбайг арчлах, хамгаалах ажил хийдэггүй, мөн ойжуулалтын ажлыг хүлээн авахдаа хавар тарьсан суулгацыг намар нөхөн тарьсан суулгацаас ялгаж тоолдоггүйгээр амьдралтын хувийг тогтоодог, тооллогын дүнг зохиомлоор өсгөдөг, хүлээж авах ажлын хэсгийн гишүүдийг тооллогын дүн гаргахад оруулдаггүй, тооллого хийх ажлын хэсэгт ойжуулалтыг хүлээн авахад арга зүйн заавар, зөвлөмжөөр хангадаггүй зэрэгтэй холбоотой байна.

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай хийсэн ярилцлага, уулзалтаар аж ахуйн нэгжүүд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлдэггүй, тарьсан суулгацыг мал иддэг гэсэн тайлбарыг өгч байгаа нь төрийн байгууллагын албан тушаалтнуудын ажилдаа хандаж байгаа хандлага, хяналт, ажлын хариуцлага, санал санаачилга хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд ойжуулалтын ажлын үр дүнг сайжруулах, цаашид өгөөжөө хэрхэн хүртээх тал дээр тооцоо судалгаа хийх, малын бэлчээр бүхий газар ойжуулалт хийсэн бол тухайн талбайг хамгаалах, хашаажуулах, ойжуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийн үүрэг хариуцлага хяналтыг сайжруулах, нэгдсэн ойлголтоор хангаж байх шаардлагатай байна.

Ойн нөхөн сэргээлтийг ажлын үр дүнд хяналт тавиагүй, тухай ажлыг хариуцсан гүйцэтгэсэн холбогдох мэргэжилтэн, албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

- *Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийн төсөвт өртөгт тусгагдсан захиалагчийн албаны зардал, магадалшгүй ажлын зардал, зохиогчийн ажлын зардал, техник хяналтын зардал, зураг төсвийн үнийг гүйцэтгэх ажлын гэрээнд тусгаагүй, тухайн зардлыг суутгаж аваагүй санхүүжилтийг бүрэн олгосон нь Барилгын тухай хуулийн 38.1.4²², 38.1.8²³, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.13²⁴, 3.19²⁵, 4.1²⁶ дахь заалтуудтай нийцэхгүй байна.*

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хэрэгжүүлсэн 7 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо Захиалагчийн албаны зардал 1072.4, зохиогчийн албаны зардал 646.9, магадалшгүй ажлын зардал 5056.5, зураг төсвийн үнэ 3500.0 нийт 10275.8 мянган төгрөгийг суутган аваагүй санхүүжилтийг олгосон зөрчилд гэрээ байгуулсан холбогдох байгууллагад хариуцуулан төлбөрийн акт тогтоолоо. /Хавсралт -4/

- *Айрагны баярыг тэмдэглэн өнгөрүүлэх зардалд аймгийн Засаг даргын захирамжаар 44798.1 мянган төгрөг зарцуулахаас 4350.9 мянган төгрөгөөр илүү буюу нийт 49149.0 мянган төгрөгийг зарцуулсан ба үүнээс 6108.5 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан нь ННБ-ийн тухай хуулийн 13.1²⁷, 13.7²⁸, 20.1.1²⁹ дахь заалтыг зөрчсөн зөрчилд дахин давтахгүй байх зөвлөмжийг аудитын явцад зөвлөн ажиллалаа.*
- *Туул голын сав газрын захиргаа нисдэг камер худалдаж авахад 5000.0, Хоггүй цэвэрхэн Монгол төсөл арга хэмжээнд 6580.8 нийт 11580.8 төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.1³⁰ дэх заалтыг зөрчсөн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.*
- *Зарим сумд байгаль хамгаалах сангийн хөрөнгийг анхан шатны баримтгүй, зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал: Тэшиг сум шатахууны зардалд 884.6, Сайхан сум*

²² зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

²³ барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахыг захиалагчаас шаардах;

²⁴ Төсвийн магадалшгүй ажлын зардлыг захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон актын дагуу олгох бөгөөд актаар тогтоогоогүй магадалшгүй ажлыг санхүүжүүлэхгүй.

²⁵ Захиалагч барилгын ажлын зардал, техник, эдийн засгийн үндэслэл зураг төслийн үнэ, техник хяналтын зардал, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ.

²⁶ Захиалагч нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд техникийн хяналт тавьж, хэмнэлт

²⁷ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

²⁸ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

²⁹ нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд

шаардан гаргуулах;

³⁰ Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

шатахууны зардалд 500.0, айрагны баярын зардалд 2000.0, Сэлэнгэ сум шатахууны зардалд 1976.5, Хялганат тосгон шатахууны зардалд 700.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан зөрчилд нийт 4061.1 мянган төлбөрийн акт тогтоож, 2000.0 мянган төгрөгийг анхан шатны бүрдэлгүй зарцуулсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг Сайхан сумын Засаг даргад хүргүүлэн ажиллалаа.

2.1.4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүрэн бүртгээгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтаас түүвэрлэн үзэхэд зарим хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчит бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4³¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2³² дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: Нийтийн эзэмшлийн талбайд хог төрөлжүүлэн хийх хогийн сав нийлүүлэх ажилд 146945.7 мянган төгрөгийг зарцуулсан, хөв цөөрөм байгуулах төсөл арга хэмжээнд 298000.0 мянган төгрөгийг зарцуулсан. Дашинчилэн сумаас бусад сум хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчит бүртгээгүй зөрчил илэрлээ.

Иймд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын үр дүнд бий болсон хөрөнгийг орон нутгийн өмчит бүртгэсэн эсэхийг нягтлан шалгаж дээрх хуулийн заалтын хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг Орон нутгийн өмчийн албанд хүргүүллээ.

Бүлэг 3 Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт хууль журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.1. Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”-ын 4 дэх хэсэгт төлбөрийн орлогын хэсгийг тайлагнах, хяналт хийх асуудал тус тус тусгагдсан байна.

3.2 Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын зарцуулалтад дотоод нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журам”-ын 4.7³³ дэх заалтад БОАЖГ байгаль орчны аудитыг хийлгэж болох зохицуулалттай боловч тухайн аудитыг хийлгэж байгаагүй байна.

³¹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...

³² Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

³³ Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь тухайн аймаг, сумын байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын хүрээнд байгаль орчны нөөц ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэж болно.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төсвийн тухай хуулийн 69.1³⁴ заасны дагуу сумдын байгаль хамгаалах сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт үр дүнд жил бүр төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн ч аймгийн байгаль хамгаалах сангийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд Санхүүгийн хяналт, аудитын алба хуульд заасны дагуу хяналт шалгалт хийх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос бусад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт бодитой бус, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын биелэлт нийт дүнгээрээ 92.9 хувьтай байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зарим сумын байгаль хамгаалагчид төсөвт тухай бүр төвлөрүүлээгүй байна.
- Аймгийн хувьд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын нийт дүнг баримталж байгаа боловч ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах зардлын дүнг хуульчилсан хувь хэмжээнээс дутуу, бусад байгалийн нөөцийг нөхөн сэргээх зардалд илүү хуваарилан зарцуулж байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1³⁵ дэх заалттай бүрэн нийцэхгүй байна.
- Сумын Засаг дарга, ИТХ байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд зарцуулах төсвийг батлахгүй, орон нутгийн урсгал зардалд зарцуулж холбогдох хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Сумын Засаг дарга нар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлж БОАЖГ-т ирүүлдэггүй.
- Сумдын баримтлан ажиллаж байгаа “Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам” аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар 31-ний өдрийн А/435 дугаар захирамжаар хүчингүй болсон байна.
- Аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар 31-ний өдрийн А/435 дугаар захирамжийн үйлчлэх хүрээ байхгүй.
- Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний 9.5 хувийг зураг, төсөв, эдийн засгийн тооцоололгүйгээр, 4.9 хувийг зориулалт бусаар төлөвлөж, зарцуулсан байна.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ холбогдох хууль дүрэм журамд бүрэн нийцээгүй байна.
- Ойг нөхөн сэргээх ойжуулалтын ажил үр дүнгүй байна.

³⁴.Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

³⁵ .Энэ хуулийн 13.2-г заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

- Тэшиг, Сайхан, Сэлэнгэ, Хялганат тосгон байгаль хамгаалах сангийн хөрөнгийг анхан шатны баримтгүй, зориулалт бусаар зарцуулсан байна.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтаас түүвэрлэн үзэхэд зарим хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчит бүртгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танаа:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, санхүүжилтийн задаргааг ИТХ-аар хянаж батлахдаа Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журамд нийцүүлэн төлөвлөх.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлт, зарцуулалтын үр дүнд хяналт - шинжилгээ үнэлгээ хийж байх.
3. Сумдын Засаг дарга, ИТХ ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.2.³⁶ заалтуудыг үндэслэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг сумын суурь зардалд оруулан тооцож тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан холбогдох хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах ажлыг зохион байгуулах.
4. Аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/435 дугаар захирамж, сумдын баримтлан ажиллаж байгаа байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмын үндэслэл, агуулгыг судалж холбогдох шийдвэрийг гаргуулах.
5. Сумын Засаг дарга нар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлж БОАЖГ-т ирүүлээгүй нь ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан төлбөрийн орлогын хэсгийн тайлагнах, хяналт тавих журмын 4.1 дэх заалтыг зөрчсөн тул хэрэгжүүлж ажиллах чиглэл өгөх.

³⁶ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна

Мэдэгдэл:

Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гарсан үр дүнгийн талаар 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр хариу ирүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН

Төсвийн тухай хуулийн 69.1 дэх заалтаар дотоод аудитын хянат, шалгалт хийж ... эрсдлээс сэргийлэх талаар дотоод хяналт хийгдээгүй байна. • Төсвийн тухай хуулийн хэрэгжилтэнд иргэдийн оролцоог хангах талаар 2017 оны 11-р сарын 28-ны өдрийн АИТХ-ын тэргүүлэгчдийн А/123 дугаар тогтоолоор “Төсвийн сахилга бат, иргэдийн оролцоо, хяналт дэд хөтөлбөр батлагдсан ч хэрэгжилт нь сул байна. • Аймгийн ИТХ-ын 2011 оны А/32 дугаар тогтоолоор “Байгаль орчинг хамгаалах сан байгуулах тухай журам” батлан хэрэгжүүлж байгаа боловч уг журмын үндэслэлд тусгагдсан МУЗГ-ын 2000 оны 52 дугаар тогтоолыг 2012 онд хүчингүй болгосонтой холбогдуулан тус журмыг шинэчлээгүй байна. • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1 ба 13.4, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын

2.1 3.1 дэх заалттай тус журмын заалт зөрчилдөж байна. Иймд уг журамд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна. • Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор баталсан Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журмын 2-д “сангийн хөрөнгийн эх үүсвэрт” нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг оруулахаар тусгаагүй байна. Барьцаа хөрөнгө нь зарим сумын Байгаль орчин хамгаалах сангийн үлдэгдэл байдлаар харагдаж байна.

Зөвлөмж:

Хууль, дүрэм, журмын заалттай аймгийн “Байгаль орчин хамгаалах сан” -гийн журам, үйл ажиллагааг үйлдүүлэх

Сумын засаг дарга нар Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон ЗГын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.2.8 дахь заалтыг үндэслэн байгаль хамгаалах сангийн төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж ажиллах шаардлагатай байна.

Гадаргын усны хатаж, ширгэсэн болон сэргэсэн эх үүсвэрийг аймгаар нь авч үзвэл, Булган, Төв аймагт гадаргын усны эх үүсвэр хамгийн их хатаж, ширгэсэн бол Хэнтий, Баянхонгор, Дорнод аймагт сэргэсэн эх үүсвэрийн тоо их байна Булган 99 ширгэсэн эх үүсвэрийн тоо

Усны тухай хуулийн дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Сав газрын захиргаад, аймаг, Нийслэлийн байгаль орчны албад ус ашиглуулах дүгнэлт гаргаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь “Усны тухай” хуулийн дагуу

хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллагуудын дүгнэлтийг гаргаж байгаа бөгөөд хоногт 100 шоометрээс их ус ашиглах зориулалтаар ус ашиглуулах дүгнэлтийг Засгийн газрын 2013 оны 390 дүгээр тогтоолын дагуу “Монгол-Ус” ТӨААТҮГ-т

“БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ЗАРЦУУЛАЛТ
“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасны дагуу сүүлийн 3 жилийн дунджийг авч үзэхэд 77.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрснөөс 10.2 тэрбум төгрөгийг зарцуулж, тус хуулийн хэрэгжилт 36.9%-тай байна. Энэхүү хуулийн хэрэгжилт 2018 онд орон нутгийн төсөвт 75.7 тэрбум төгрөгний орлого хуримтлагдсан боловч тус хуулийн 18.1-д байгалийн нөөц бүрийг ашигласны төлбөрийн орлогын 15-85% буюу тухайн жилийн төсөвт зарцуулах хувийн доод хязгаарыг зааж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна гэж заасны дагуу ажлын гүйцэтгэлийг тооцоход 2018 онд 25.4 тэрбум төгрөгийг зарцуулахаас 9.3 тэрбумыг зарцуулж,

Аймгийн ИТХ нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг тогтоох тухай тогтоол гаргаагүй нь БОХТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Ахуйн зориулалтаар агнах, барих ан амьтны зөвшөөрлийн эрхийн бичгийг БОАЖЯ-аас аймгийн БОАЖГ нь авч сумдын байгаль хамгаалагч нарт олгож байгаа бөгөөд уг эрхийн бичгийн орлого нь сумдын төрийн сангийн орон нутгийн орлогын “Ан агнуурын нөөцийн орлого”-д төвлөрч байгаа гэх үндэслэлээр ан агнах, барих зөвшөөрлийн эрхийн бичгийн үнэт цаасны тооцоог огт бодогдоогүй хэн, хэрхэн хяналт тавьж ажилладаг нь тодорхойгүй байна. Ан амьтныг агнах, барих эрхийн бичгийн эхний болон эцсийн үлдэгдэл хөдлөл өөрчлөлт, түүнээс төвлөрүүлэх төсвийн орлогын гүйцэтгэлд сумдын Санхүүгийн албанаас хяналт тавьж ажиллаагүйгээс шалтгаалан сумын байгаль хамгаалагчид их хэмжээний үнэт цаасны үлдэгдэлтэй байгаа бөгөөд эрхийн бичгийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй хүчингүй болсон эрхийн бичгийг устгалд оруулаагүй байна. Цаашид БОАЖГ нь ан амьтан агнах эрхийн бичгийг олгохдоо сумдын Санхүүгийн албаар дамжуулан олгож, үнэт цаасны орлогын тооцоог тулган урьд нь олгосон үнэт цаасны тооцоог бодуулсан баримтыг үндэслэн үлдэгдлийн тоо хэмжээг харгалзан дараагийн үнэт цаасыг олгож байх, шаардлагатай байна.

сумдын байгаль хамгаалах санд төвлөрсөн байгалийн нөөцийг хууль бусаар ашигласан торгуулийн орлого, ойжуулалтын нөхөн төлбөрийн орлогын хэмжээг үндэслэн төлөвлөж байна. 2019 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Аймгийн хэмжээнд ойн нөөцтэй сумд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.3³⁷ -д заасан арга хэмжээнд зарцуулах төсвийг төлөвлөхдөө хуульд заасан хувь, хэмжээг баримтлаагүй төлөвлөсөн байна. сумдын байгаль хамгаалах санд төвлөрсөн байгалийн нөөцийг хууль бусаар ашигласан торгуулийн орлого, ойжуулалтын нөхөн төлбөрийн орлогын хэмжээг үндэслэн төлөвлөж байна.

2019 онд ойн нөөц Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1³⁸ - д ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.3³⁹ -д заасан арга хэмжээнд зарцуулахаар заасан байна.

Аймгийн хэмжээнд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого нийт 313556.2 мянган төгрөг төвлөрсөн бөгөөд ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 266522.7 зарцуулахаас төгрөг зарцуулсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай 13 дугаар зүйлийн 13.4⁴⁰,

³⁷ Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.4-т заасныг үндэслэн:

³⁸ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

³⁹ Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.4-т заасныг үндэслэн:

⁴⁰

18 дугаар зүйлийн 18.1-д заасныг биелүүлээгүй байна. төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 2.1 Засаг дарга нь тухай жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.16-д заасан хувь хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухай шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар заажээ.

Мөн ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэсэн аж ахуй нэгж 3 жилийн хугацаанд тарьсан ойгоо арчлан хамгаалахыг ойг хүлээн авах ойжуулсан талбай бүрт хувийн хэрэг хөтөлж БОАЖГ-т ойн мэдээллийн санд нэгдсэн санд хадгуулах зэрэг ажлууд мөн хангалтгүй байгаа нь Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2013 „„„„„,оны хамтарсан тушаалын заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тухайлбал: Ойжуулсан талбай бүрийн хувийн хэргийн БОАЖГ-аас ирүүлээгүй зөвхөн ойжуулалт хүлээн авсан акт, нөхөн тарилт хийсэн ойжуулалтын ажил хүлээж авсан актыг ирүүлсэн, ойжуулалтын нөхөн тарилтыг 2016 онд 1, 2017 онд 2, 2018 онд 3 талбайд хийснийг хүлээж авсан боловч аудитын явцад газар дээр очиж үзсэн ойжуулалт ойролцоогоор 10 хувьтай байсан.